# ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРХ ЗҮЙН СОЛБИЦОЛ НЬ САЛБАР ЭРХ ЗҮЙН ТҮВШИНД ҮНЭЛЭГДЭХ ҮҮ?

**М.Хатанзориг**
*Шихихутуг их сургуулийн багш*

**Товч агуулга:** “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах боломжтой эрх зүйн хүрээнд тодорхойлох, хангах ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын хүрээнд явагддаг тул ойлголт, концепц болон харилцааны зохицуулалт зэрэг нь тодорхой шугам дээр давхцаж, солбилцох нь ойлгомжтой. Үүнийг “Үндэсний аюулгүй байдлын эрх зүй” хэмээн ойлгох боломжтой. Харин уг солбицол нь эрх зүйн бие даасан салбарын түвшинд үнэлэгдэх хэрэгцээ, шаардлага бий юү гэдгийг давхар судлах хэрэгцээ бий болж байна.”

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд зааснаар “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”. Онолын хувьд ч эл ойлголт нь аливаа улсын оршин тогтнохуйн баталгааг тодорхойлдог амин чухал аксиом юм. Аюулгүй байдлын үндсэн элементүүд нь хэдий *батлан хамгаалах болон эдийн засгийн салбар, соёлын бодлого, мэдээлэл технологи зэрэг эрх зүйтэй харьцуулахад илүү бодит хүчин зүйлст төвлөрдөг болович* ***тэдгээртэй холбоотой нийгмийн харилцаа, зохион байгуулалт, зохицуулалт, журам нь зрх зүйн үзэл сэтгэлгээнд тулгуурласан хэм хэмжээгээр нөхцөлддөг*** учраас үндэсний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын ач холбогдол нь зохицуулж буй харилцааныхаа үнэ цэнээр хэмжигдэнэ.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд үндэсний аюулгүй байдлын эрх зүйг бие даасан эрх зүйн салбар гэж үнэлдэггүйн[107] зэрэгцээ дэлхийн бусад улсуудын жишгээр Үндсэн хууль, дагнасан органик хууль буюу үзэл баримтлалаас гадна батлан хамгаалахын багц хууль, эдийн засгийн бодлогын зохицуулалтын баримт бичиг, мэдээлэл технологийн тухай хууль тогтоомж зэргийн харилцан уялдаат байдлаар системчлэгддэг. Гэвч 1974 онд Америкийн Нэгдсэн Улс баталсан дэлхийн анхны “Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн баримт бичиг”-ээс хойш *нийгмийн болон олон улсын харилцааны агуулга, хэлбэр хийгээд аюулгүй байдлын талаарх ойлголт, үзэл*

[107] Тэр бүүхэл одоохондоо ойлголтын хувьд ч “Үндэсний аюулгүй байдлын эрх зүй” гэж байх эсэх талаар маргаантай байна.

*сэтгэлгээнд ихээхэн өөрчлөлт гарсан явдал нь эрх зүйгээр зохицуулж буй нийгмийн харилцааны өвөрмөц хэлбэрийг бий болгосон* юм.

Үндэсний аюулгүй байдлын эрх зүйд зохицуулж буй харилцаа нь “төр, нийгэм, иргэний” гурван өөр түвшний ашиг сонирхол, харилцааг нэг дор зангидан зохицуулдаг[108] [109], зургаан төрлийн хүчин зүйлийг харгалзан хэм хэмжээчлэх [109] зэрэг онцлогуудаас шалтгаалаад ***орчин үеийн нийгмийн шаардлагад нийцсэн зохицуулалтыг хийхэд норматив эрх зүйд суурилсан нийтлэг хандлага, системээр шууд хандахад тохиромжгүй байна.***

Хууль зүйн шинжлэх ухаанд аливаа нийгмийн харилцааны нийтлэг шинжийг нэгтгэн эрх зүйгээр зохицуулсныг салбар эрх зүй хэмээн нэрлэдэг. Салбар эрх зүйн тухай онолын хувьд тухайн салбар эрх зүйг бие даасан салбар эрх зүй мөн гэж үзэхийн тулд:

1. Зохицуулах зүйл
2. Зохицуулалтын арга
3. Зарчим зэргийг харгалзан үзэж бусад эрх зүйн салбар системүүдээс ялгах явдал Ром-Германы эрх зүйн бүлд багтдаг улсуудын хувьд түгээмэл хандлага. Жишээ нь: Иргэний эрх зүйн зохицуулах зүйл “Иргэн, хуулийн этгээд хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой нийгмийн харилцаа” байдаг бол зохицуулалтын арга нь “императив буюу захиргааны, диспозитив буюу зөвшилцлийн” гэж хуваагддаг.

Одоогоор хууль зүйн шинжлэх ухаанд салбар эрх зүйн онол төдийлэн ач холбогдол бүхий байр суурийг эзэлдэггүйгээс гадна эрх зүйн салбарыг бие даасан хэмээн тооцох баталгаатай тогтсон үзэл ч бүрэн бүрэлдэж бий болоогүй гэж хэлж болно. Зарим судлаач[110] эрх зүйн бие даасан салбарыг тодорхойлохдоо:

- Хэрэглэх нэр томьёо

[108] Иргэний болон захиргааны эрх зүйтэй адилаар өөрийнхөө зохицуулдаг салбар, зарчимдаа субьектээ нийцүүлж хэвтээ, босоо харилцаа үүсгэхгүйгээр **тухайн харилцааны түвшинг байгаа чигээр нь хүлээн авч (эрх зүй төвт бус) зохицуулдаг** гэдгийг ойлгоно.

[109] “Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна” /ҮАБҮБ 1.2.3 хэсэг/ - **харилцан адилгүй материаллаг хүчин зүйлс, нийгмийн салбар харилцаануудыг нэг зарчмын дор хамтад нь зохицуулж буй** байдлыг ойлгоно.

[110] Хууль зүйн шинжлэх ухааны шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын гавъяат хууль О.Амархүү экологийн эрх зүйг бие даасан салбар эрх зүй мөн гэж үзэхдээ дээрх арга зүйг ашиглажээ.

- Зохицуулах зүйл
- Зохицуулах арга
- Харилцааны бүтэц
- Судлах арга
- Тогтолцоо
- Зарчим
- Иж бүрдэл шинж зэргийг харгалзан үзжээ.

**Аливаа эрх зүйн салбарыг бие даасан гэж үзэх онолын болон практик хэрэгцээ, шаардлага, ач холбогдлоор тодорхойлогддог бөгөөд тухайн шаардлага түүнийг бие даасан гэж үзэх арга зүйг тодорхойлдог.** Энэ ч утгаараа салбар эрх зүй гэж үзэх үндэслэлд эрх зүйн эх сурвалж, хариуцлага буюу санкц, удирдлагын тогтолцоо зэрэг ч хамаарч болно гэсэн үг.

*Үндэсний аюулгүй байдлыг эрх зүйн бие даасан салбар гэж үзэх хэрэгцээ, шаардлага:*

- Үндэсний аюулгүй байдлыг хангах харилцаанд эрх зүйн хийдэл, давхардал, зөрчилгүй, нягт, иж бүрэн байх

(Иж бүрэн байх гэдэгт Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх аливаа үйлдэл, эс үйлдэхүйн нийтлэг шинжийг тодорхойлж нийгмийн бүхий харилцаанд (Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн харилцаанд) дагаж мөрдүүлэх боломж бүрдсэн байхыг ойлгоно. Жишээ нь: Төрийн албаны тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.8 дахь хэсэгт зааснаар Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцна. Уг заалтыг баримтлан Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн шүүхийн шүүгч Э.Золзаяа иргэний 120 сая төгрөгийн нэхэмжлэлийг хангасан шийдвэр гаргажээ.[111] Төрийн албан хаагчийн баталгааг тогтоож буй эл заалтын үндэс Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэх заалт юм. Гэтэл уг заалтын агуулга эмчилгээний

[111] www.shuukh.mn

төлбөрийг хариуцах тухай биш боловч иргэний эрх зүйн зохицуулалтаар тийнхүү төлсөн явдал зөв гэж үзэж болно. Энэ үүднээс харвал, салбар эрх зүй болгон өөр өөрийнхөө зарчим, зохицуулалтаараа аливаа харилцаан дахь “зөв”-ийг тогтоодог боловч тэр нь өөр хоорондоо зөрүүтэй байх эрсдэлтэй байна. Дээрх тохиолдол үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Гэтэл нэгдсэн зохицуулалт дутмаг буюу үндэсний аюулгүй байдлын эрх зүй гэх чиг шугам тогтоосон салбар эрх зүй байхгүйн улмаас ийм тохиолдол бий болсоор байна.)

- Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тогтоосон хэм хэмжээг хэрэглэх хууль хэрэглээ, онолын оновчтой систем, боломж бий болгох[112]
- Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн онцлог шинж[113]

***Үндэсний аюулгүй байдлын эрх зүйг салбар эрх зүй болохынх нь хувь зарим элементүүдийг товч тайлбарлавал:***

**Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн нэр томъёо:**

*Нэр томъёо тухайн эрх зүйн салбарыг бие даасан гэж үзэх үндэслэл болохын хувьд үндсэн агуулгыг өөр салбар эрх зүйд биш гагцхүү тухайн эрх зүйн салбарт тодорхойлдог бөгөөд бусад салбар эрх зүйд тэрхүү агуулгаар авч ашигладаг байхыг шаардана.*

Үндсэн агуулгыг бусад салбар эрх зүйгээр биш гагцхүү үндэсний аюулгүй байдлын эрх зүйгээр тогтоодог нэр томъёоноос дурдвал:

*Үндэсний аюулгүй байдал* - “Үндэсний аюулгүй байдал” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.[114] Үндэсний аюулгүй байдлын талаарх ойлголт тодорхойлолт хүн төрөлхтний түүхийн цаг үед нийгмийн харилцааны төлөв шинжүүдийг даган хувьссаар ирсэн юм. XX зууны хоёрдугаар хагасаас өмнө батлан хамгаалах салбарыг буюу цэрэг дайны асуудлуудыг үндэсний аюулгүй байдалд тооцдог байсан бол өнөөдөр эдийн засаг, экологийн баталгаа, соёл иргэншил зэрэг олон бүрэлдэхүүн хэсгүүдийг хамруулан тооцдог болжээ.

[112] Эрх зүйн бусад салбарт хууль хэрэглэхдээ өөрийн салбарын зарчим, системийг баримталдаг. Жишээ нь: экологийн эрх зүйд аливаа зөрчилд хариуцлага тооцохдоо өөрийнхөө салбар хэм хэмжээнд тулгуурладаг бол экологийн тэнцвэрт хөгжилд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болохынх нь хувьд хохирол учруулсан, зөрчил гаргасан бол үндэсний аюулгүй байдлын эрх зүйгээр хариуцлага хүлээлгэх шаардлага бий.
[113] М.Хатанзориг “Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн үзэл сэтгэлгээний зарим асуудал" сэдэвт магистрын ажлаас дэлгэрүүлж үз. /УБ., 2017 он. Хууль Сахиулахын Их Сургууль/
[114] Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 он. 3.1 хэсэг.

*Үндэсний язгуур ашиг сонирхол* - Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал. эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

*Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа* - Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ.

- **Зохицуулах зүйл:**

эрх зүйн зохицуулах зүйл аливаа эрх зүйн салбар үүсэн бий болж бүрдэн тогтох, нийгмийн харилцааны тодорхой салбарыг бусад харилцааныхаас нь ялган үзэх, түүнчлэн тодорхой нэгэн эрх зүйн салбар доторх эрх зүйн хэм хэмжээг бүлэгчлэн ангилахад гол үүрэг гүйцэтгэдэг байна.[115]

*Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулах зүйл өргөн утгаараа үндэсний аюулгүй байдлын талаарх нийгмийн хүсэл зоригийн харилцаа мөн.* Үндэсний аюулгүй байдлыг үздэг эрх зүйн философийн үзэл нь маргаантай байдаг учраас өргөн утгаар тодорхойлох нь зүйтэй. Позитив эрх зүйн үүднээс үндэсний аюулгүй байдлын эрх зүйн концепц, үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагааны, үндэсний аюулгүй байдлын удирдлага, тогтолцоо гэх гурван төрлийн асуудал түүний дотоод бүтцэд хамаарч институц болно.[116]

**Зохицуулах арга:**

Эрх зүйн зохицуулалтын арга гэдэг бол төрийн зүгээс нийгмийн харилцаанд үзүүлэх эрх зүйн нөлөөллийн арга мөн.[117] *Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн хувьд түүнийг эрх зүйн хувьд ойлгож тодорхойлох, хангах ажиллагаа, тогтолцоог зохицуулах асуудлаар концепцийг харгалзаж оролцогчдын зан төлөвт эрх зүйн хэм хэмжээгээр ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхээр төрөөс хэрэгжүүлдэг үйл ажиллагаа юм.*

Аливаа эрх зүйн салбар зохицуулалтын дан ганц өөрийн аргатай байдаггүй бөгөөд эрх зүйн бусад салбаруудтай сүлэлдэж, тэдний зохицуулалтын аргыг харилцан авч хэрэглэж байж зорилтоо гүйцэлдүүлдэг ёстой.[118]

Энэ утгаараа үндэсний аюулгүй байдлын эрх зүй:

[115] О.Амархүү. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ.,2009 он 38 тал
[116] Үндэсний аюулгүй байдлын ойлголт, онол хандлага хэсгээс дэлгэрүүлж үз.
[117] О.Амархүү. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ.,2009 он 44 тал
[118] О.Амархүү. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ.,2009 он 45 тал

- Эрх олгох
- Зөвшөөрөх
- Хориглох
- Албадах
- Тэгш эрхийн зохицуулалт

зэрэг аргуудаар зохицуулагдана.

Бие даасан эрх зүйн салбар болохын хувьд уг сэдвийн хүрээнд шинжлэх ухааны тогтмол, арга зүйн тодорхой нийтлэг шинж бүхий судалгаа хийгдэх учиртай. Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн судалгаа бол шинжлэх ухааны танин мэдэхүйн нэг төрөл мөн. Уг танин мэдэхүй нь онолын болон эмпирик түвшинд хэрэгжинэ. Уг судалгааны аргад танин мэдэх гэж байгаа зүйлээ ямар аргаар судалбал илүү хялбар, үр ашигтай, өгөөжтэй байж болох шинжлэх ухааны тогтсон төсөөлөл, ойлголт, хэрэглээг хэлдэг байна.

Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн судалгаанд судалгааны эмпирик, эмпирик болон онолын, онолын аргуудыг оновчтой байдлаар уялдуулж ашигласнаар түүний парадигмыг[119] боловсруулах боломжтой юм. Парадигм бол шинжлэх ухааны өмнө тулгарсан асуудлуудыг шийдвэрлэхэд бусад хуучирсан аргуудыг бодвол илүү өгөөжтэй, ирээдүйтэй арга гэж эрдэмтэд үзэж байгаа юм. Хуучин арга бол аливаа зүйлийн учир шалтгааныг ертөнцийг үзэх механик үзэлд тулгуурлан тайлбарладаг арга байв. Механик үзэл бол аливаа юмс үзэгдлийг учир шалтгаан-харилцан үйлчлэл гэсэн гинжин холбоосын загвараар тайлбарладаг үзэл юм.[120]

Парадигм нь аливаа зүйлийг мөнхийн хөдөлгөөнд байдаг гэж үздэг. Тиймээс үндэсний аюулгүй байдлын эрх зүйг өнгөрсөн, одоо, ирээдүй буюу уламжлал, залгамжлал, шинэчлэл хэмээн мөнхийн хөдөлгөөнд авч үзэж судална. *Мөн уг эрх зүйн онцлогууд түүнийг бие даасан салбар эрх зүй гэж үзэх үндэслэл болно.*[121]

Хэрэв бие даасан салбар эрх зүй гэж үзвэл Үндэсний аюулгүй байдлын эрх зүйг идеалист(1), позитивист(2) онолын үүднээс дараах байдлаар тодорхойлж болохоор байна: Нэгдүгээрт: “Үндэсний аюулгүй байдал, түүний баталгаажсан байдлын зохицуулалтын талаарх нийгмийн нийтлэг төсөөллийг агуулсан байх ёстой хэм хэмжээг хэлнэ.” Хоёрдугаарт: “Үндэсний аюулгүй байдал, түүний баталгаажсан байдлыг тодорхойлох, түүнтэй холбогдсон

[119] Парадигм бол аливаа юмс, үзэгдэлд алгуур хөгжил, хувьслын үүднээс хандах үзэл.
[120] О.Амархүү. Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ., 2009 он 47 тал
М.Хатанзориг “Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн үзэл сэтгэлгээний зарим асуудал” сэдэвт магистрын ажлаас дэлгэрүүлж үз. /УБ„ 2017 он. Хууль Сахиулахын Их Сургууль/

нийгмийн харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогцыг хэлнэ."

Эцэст нь дүгнэхэд, хууль тогтоомж, түүний төрөлжүүлэлт, эрх зүйн системчлэл. зохицуулалт нь байх ёстой тогтсон ойлголт бус *хэрэгцээ, шаардлага* юм. Аливаа зүйлд эрх зүйн үүднээс хэрхэн хандах нь үзэл баримтлал. арга зүй бүхий онолуудад тулгуурладаг (өнөөгийн нөхцөлд норматив эрх зүйн онолд) нь зүйн хэрэг боловч аль нэг онолыг хэт хатуу баримтлах нь бас оновчтой бус. Тухайн харилцааг хэрхэн, яаж зохицуулбал, зохицуулалтаа хэрхэн системчилбэл илүү прагматик хэрэгцээг хангаж байгааг нь л илүүтэй харгалзах нь хууль тогтоомжийг зорилгыг хэрэгжүүлэхэд илүү тустай билээ. Ардчилсан дэглэмд үндэсний аюулгүй байдлыг эрх зүйт төрийн зарчимд тулгуурлан хангах нь ойлгомжтой тул эрх зүй болон үндэсний аюулгүй байдлын харилцан хамаарал нь абсолют шинжтэй. Харин уг хамаарал зохицуулалтыг эрх зүйн бие даасан салбарын түвшинд үнэлж, системчлэх хэрэгцээ шаардлага буйг уг өгүүлэлд дурдлаа. Цаашид уг сэдвийн хүрээнд эрх зүй судлалын ажлуудыг улам нэмэгдүүлэх, эрчимжүүлэх шаардлагатай байна.